



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 9 (438)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай*
- *Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны гуравдугаар сарын 7

№9 (438)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |     |
|------|--|-----|
| 114. | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 230 |
| 115. | Монгол Улс, БНХАУ-ын улсын хилийг хоёр дахь удаа хамтран шалгасан тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын протокол, түүний хавсралтуудыг соёрхон батлах тухай | 230 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 116. | Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай  | Дугаар 07 | 230 |
| 117. | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 12 | 236 |
| 118. | Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай  | Дугаар 23 | 236 |
| 119. | Тогтоолд нэмэлт оруулах тухай  | Дугаар 24 | 236 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 120. | Мөөгөний Жаргалд хошууч генерал цол хүртээх тухай                       | Дугаар 11 | 237 |
| 121. | Ядмаагийн Чойжамцад хошууч генерал цол хүртээх тухай                    | Дугаар 12 | 237 |
| 122. | Гонгорын Хайдавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай      | Дугаар 13 | 237 |
| 123. | Шаравын Шагдарт Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай               | Дугаар 14 | 237 |
| 124. | Лэгшидийн Чуваамэдэд Монгол Улсын ардын зураач цол хүртээх тухай        | Дугаар 15 | 237 |
| 125. | Түмэнбаярын Рагчаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 16 | 238 |
| 126. | Бадрахын Сангажавт Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай      | Дугаар 17 | 238 |
| 127. | Ринченгийн Индрад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай           | Дугаар 18 | 238 |
| 128. | Цэдэнбалын Батсуурьт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай        | Дугаар 19 | 238 |
| 129. | Нанзадын Цэндэд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай             | Дугаар 20 | 238 |
| 130. | Дандарын Дашилаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай           | Дугаар 21 | 239 |
| 131. | Жадамбын Пүрэвжавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай          | Дугаар 22 | 239 |
| 132. | Лувсанямын Гавалмаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай        | Дугаар 23 | 239 |

133.	Сандагийн Лхагвадоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 24	239
134.	Балдандоржийн Төмөрт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 25	239
135.	Дашзэвэгийн Галсантогтоход Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 26	240
136.	Чимэдийн Гомбод Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 27	240
137.	Баяраагийн Наранбаатар, Цогтбазары Энхжаргал нарт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 28	240
138.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 29	240

## Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

139.	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 2/01	245
------	--	-------------	-----

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

#### УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6.3-ын "энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жилийн дотор", 12.3-ын "2006 оны 2 дугаар сарын 1-ний дотор" гэснийг "2009 оны 2 дугаар сарын 1-ний дотор" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 2 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

#### МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН УЛСЫН ХИЛИЙГ ХОЁР ДАХЬ УДАА ХАМТРАН ШАЛГАСАН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ПРОТОКОЛ, ТҮҮНИЙ ХАВСРАЛТУУДЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2005 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Бээжин хотноо гарын үсэг зурсан "Монгол Улс, БНХАУ-ын улсын хилийг хоёр дахь удаа хамтран шалгасан тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын протокол", түүний хавсралтуудыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

#### Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай

Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

1/ хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж байх;

2/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжийн хөрөнгийн зохих хэсгийг хуваарилах ажлыг зохион байгуулах;

3/ хөтөлбөрт нийцүүлэн Засгийн газар, яам, агентлаг, орон нутгийн байгууллагын захиргааны статистик мэдээллийг сайжруулах арга хэмжээ авах.

**3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч**

хэрэгжүүлэхийг Үндэсний статистикийн газар /П.Бямбацэрэн/-т даалгасугай.

1/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний статистикийн газрын зөвлөлөөр батлуулах;

2/ хөтөлбөрийн биелэлтийг Улсын Их Хуралд жил тутам тайлагнаж байх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Л.Гантөмөр/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ЦНЯМДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны  
07 дугаар тогтоолын хэвсрэлт*

**АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР  
/2006-2010/**

**Нэг. Хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх хугацаа**

1.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь албан ёсны статистикийн үйл ажиллагааны зорилт, бодлого, арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт, санхүүжүүлэлт болон хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү хөтөлбөрийг 2010 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

**Хоёр. Албан ёсны статистикийн үйл ажиллагааны зорилт**

2.1. Албан ёсны статистикийн үйл ажиллагааны ерөнхий зорилт нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон улсын нийтлэг арга зүйд тулгуурласан статистикийн үндэсний стандартыг бий болгох, статистикийн үйл ажиллагаанд мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар хэрэглэгчдийг статистик мэдээллийн чанартай, шуурхай үйлчилгээгээр хангахад оршино.

2.2. Албан ёсны статистикийг хөгжүүлэх зорилтын хүрээнд макро эдийн засгийн статистикийг хөгжүүлэх, эдийн засгийн статистикийг хөгжүүлэх, хүн ам, нийгмийн статистикийг хөгжүүлэх, мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх, хүний нөөцийн удирдлагыг хөгжүүлэх, статистикийн арга зүй, судалгааг шинжилгээ, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх дэд зорилтуудыг хэрэгжүүлнэ.

**Гурав. Макро эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт**

3.1. Макро эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт нь үндэсний тооцооны системийг бүрэн нэвтрүүлэх, макро эдийн засгийн

түвшинд эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүдийн арга зүйг боловсронгуй болгоход чиглэгдэнэ.

3.2. Макро эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

3.2.1. хуримтлалын дансны бүрэлдэхүүн хэсэг болох санхүүгийн данс, активуудын өөрчлөлтийн данс, хөрөнгийн дахин үнэлгээний дансыг олон улсын аргачлалын дагуу 5 сектороор байгуулах, туршилтын тооцоог нэвтрүүлэх;

3.2.2. актив, пассивын тэнцлийг зохиож, судалгаа, тооцоонд ашиглах;

3.2.3. нийт хөрөнгийн хуримтлалыг оны эхний болон эцсийн зөрүүнд үндэслэн тооцдог арга зүйд бүрэн шилжих;

3.2.4. эдийн засаг, байгаль орчны нэгдсэн дансыг зохиож, байгаль орчны үзүүлэлтээр дотоодын нийт бүтээгдхүүн/ цаашид "ДНБ" гэх/-ийг засварлан тооцох ажлын бэлтгэлийг хангах, цаашид нэвтрүүлэх;

3.2.5. үйлдвэрлэлийн аргаар болон зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ийг давхар дефлятороор үнэлэх тооцооны аргад шилжих;

3.2.6. орлогын болон эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлэх тооцооны аргад шилжих;

3.2.7. ДНБ-ийг худалдан авах чадвар/ паритет/-аар нь үнэлэх тооцоог боловсронгуй болгох;

3.2.8. далд эдийн засгийг шууд болон шууд бүс аргаар тооцож, үр дүнг ДНБ-ний тооцоонд тусгах;

3.2.9. хэрэглээний үнийн индекс тооцох хэрэглээний сагс, жин, суурь огноог шинэчлэн, хэрэглээний үнийн улсын нэгдсэн индекс тооцдог болох;

3.2.10. бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг сектороор ангилах кодыг нэвтрүүлж, эдийн засгийн салбарын бүтээгдэхүүний тооцоог сектороор гаргадаг тогтолцоонд шилжих.

3.3. Макро эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилтыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

3.3.1. олон улсын жишигт нийцсэн үндэсний тооцооны систем 93/цаашид "ҮТС-93"гэх/-ыг бүрэн нэвтрүүлэх;

3.3.2. макро эдийн засгийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын хэмжээнд зэрэгцүүлэх боломж бүрдэнэ.

### **Дөрөв. Эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт**

4.1. Эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт нь эдийн засгийн статистикийн үйл ажиллагаанд олон улсын нийтлэг арга зүйг нэвтрүүлэх, үзүүлэлтийн системийг боловсронгуй болгох, статистикийн түүвэр болон нэлэнхүй судалгааг статистик нэгжид тулгуурлан явуулах чадавхийг бий болгоход чиглэгдэнэ.

4.2. Эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

4.2.1. газар тариалангийн салбарын статистик мэдээллийг боловсронгуй болгож, эдийн засгийн данс байгуулахад шаардагдах үзүүлэлтүүдийг бий болгох;

4.2.2. мал тооллогод түүвэр судалгааны аргыг хэрэглэх боломжийг судалж турших, мал аж ахуйн бүтээгдэхүүний өртөг, зардлын бүтэц, үнийн судалгааг явуулж мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний тооцоонд тусгах;

4.2.3. "бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал"-ыг салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн тооцоонд бүрэн нэвтрүүлэх;

4.2.4. сэргээгдэх эрчим хүчний статистик мэдээллийг бий болгож, хэрэглэх;

4.2.5. барилгын салбарын бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнээр болон богино хугацааны давтамжтайгаар тооцох үзүүлэлтийн системийг бий болгох;

4.2.6. дотоод худалдааны салбарт жижиглэн худалдаалах бараа гүйлгээний статистикийг бий болгож нэвтрүүлэх;

4.2.7. мэдээлэл, холбооны салбарын статистикийг боловсронгуй болгож олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа нийтлэг үзүүлэлтүүдийг бий болгох;

4.2.8. "Цахим Монгол" хөтөлбөрт тусгагдсан цахим засаглал, цахим арилжаа, цахим үйлдвэрлэлтэй холбоотой статистикийн үзүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж хэрэглэгчдэд мэдээлдэг болох;

4.2.9. үл хөдлөх хөрөнгийн түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны статистикийн үзүүлэлтүүдийн талаархи мэдээллийг бий болгох;

4.2.10. байдаль орчны статистикийн үзүүлэлтүүдийг олон улсын стандарт, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгох;

4.2.11. аж ахуйн нэгж, байгууллагын ээлжит тооллогыг явуулж, тооллогын үр дүнд тулгуурлан статистикийн мэдээлэгчийн нэгжийг байгуулах;

4.2.12. статистикийн мэдээлэгчийн нэгжид суурилсан түүвэр судалгааг эдийн засгийн салбаруудаар явуулж хэвшүүлэх.

4.3. Эдийн засгийн статистикийг хөгжүүлэх дэд зорилтыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.3.1. "ҮТС 93", ДНБ-ний тооцоонд шаардагдах мэдээлэлтэй болно;

4.3.2. статистикийн мэдээлэл, судалгааны хамралтын хүрээ өргөжиж, эдийн засгийн салбарын нэмэгдэл өртгийн тооцооны үндэслэл сайжирна.

### **Тав. Хүн ам, нийгмийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт**

5.1. Хүн ам, нийгмийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт нь хүн амын бүртгэлийг сайжруулж, хүн ам зүй, нийгмийн статистикийн мэдээллийн чанарыг дээшлүүлэн олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа нийтлэг арга зүйд нийцүүлэх, ядуурал, хүн амын амьжиргааны түвшин, хэрэглээний үндсэн үзүүлэлтүүдийг орон нутгийн түвшинд тооцдог болоход чиглэгдэнэ.

5.2. Хүн ам, нийгмийн статистикийг хөгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

5.2.1. мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүд, түүнчлэн хүний хөгжлийн илтгэлийн үзүүлэлтүүдийг олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа нийтлэг арга зүйд нийцүүлэн тооцдог журамд шилжих;

5.2.2. өрхийн орлого, зарлагыг судлах, энэхүү судалгааны арга зүйг боловсронгуй болгон өргөжүүлэх;

5.2.3. өрхийн ядуурлын түвшинг тодорхойлох аргачлалыг боловсруулж мөрдүүлэх, ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг бүрэн тооцдог болох;

5.2.4. хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох;

5.2.5. хүний хөгжил, хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдийг аймаг болон бүс нутгаар тооцож мэдээлдэг болох;

5.2.6. хүн ам зүй, нийгмийн статистикийн үзүүлэлтүүдийг олон улсын стандарт, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгох;

5.2.7. хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг засаг захиргааны анхан шатны нэгжид бий болгох;

5.2.8. зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр 2010 онд хүн ам, орон сууцны улсын тооллого явуулах;

5.2.9. хүн амын дотоод, гадаадад шилжих хөдөлгөөний бүртгэлийг олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгох;

5.2.10. ажиллах хүчний судалгааг улирал тутам тогтмол явуулах;

5.2.11. хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүд, тэдгээрийн ойлголт, тодорхойлолтыг шинэчлэн боловсронгуй болгож олон улсын хөдөлмөрийн статистикийн стандарт үзүүлэлтүүдээр бүрэн тооцдог болох;

5.2.12. албан бус хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, тэдгээрийн ойлголт, тодорхойлолтыг олон улсын нийтлэг стандарт, арга зүйд нийцүүлэн боловсруулж нэвтрүүлэх;

5.2.13. шүүх, гэмт зэргийн статистик мэдээллийг олон улсын арга зүйн дагуу гаргаж хэрэглэгчдэд тогтмол хүргэж байх.

5.3. Хүн ам, нийгмийн статистикийг хөгжүүлэх дэд зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

5.3.1. олон улсын хэмжээнд харьцуулалт хийх, нэгдсэн арга зүйтэй хүн амын амьжиргаа, ядуурал, ажилгүйдлийн үзүүлэлтийн системтэй болно;

5.3.2. хүн ам, ерхийн бүртгэлийн мэдээллийн чанар, хүртээмж сайжирна;

5.3.3. хүн ам, нийгмийн статистикийн чиглэлээр хийгдэж байгаа тооцоо, судалгаануудын хамралтын хүрээ сайжирч, түүвэрлэлтийн төлөөлөх чадвар дээшилнэ.

### **Зургаа. Статистикийн арга зүй, судалгаа, шинжилгээг хөгжүүлэх дэд зорилт**

6.1. Статистикийн арга зүй, судалгаа, шинжилгээг хөгжүүлэх дэд зорилт нь олон улсын нийтлэг арга зүйд нийцсэн үндэсний стандартыг бий болгох, статистикийн судалгаа, шинжилгээнд загварчлал, хэтийн төлөв байдал, таамаглал, хүчин зүйлийн нөлөөллийг задлан шинжлэх арга зүйг нэвтрүүлэх замаар статистикийн судалгаа, шинжилгээн дэх шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулахад чиглэгдэнэ.

6.2. Статистикийн аргачлал, судалгаа, шинжилгээг хөгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.2.1. статистик мэдээлэл, судалгааны үзүүлэлтийн тодорхойлолт, ангилал, тооцоо арга зүйг олон улсын жишигт нийцүүлэн байнга сайжруулах;

6.2.2. "УТС-93" арга зүйд нийцүүлэн, өөрийн орны онцлогийг тусган үндэсний стандартыг боловсруулах;

6.2.3. далд эдийн засгийг судлах арга зүйг боловсруулж, үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэх;

6.2.4. нийгэм, эдийн засгийн судалгаанд түүвэр судалгааны аргуудыг өргөн хэрэглэх боломжийг судалж нэвтрүүлэх;

6.2.5. үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд, түүний дотор Мянганы хөгжлийн зорилт, Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, хянах үзүүлэлтийн системийг бий болгох;

6.2.6. нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч байгаа өөрчлөлтийг дагалдан бий болсон, цаашид зайлшгүй тооцоо шаардлагатай статистикийн үзүүлэлтүүдийг бүрэн тооцдог болох;

6.2.7. албан ёсны болон захиргааны статистик мэдээллийн арга зүйн уялдааг хангах замаар үр ашгтай мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох;

6.2.8. статистикийн мэдээ, судалгаа, улсын тооллогын мэдээллийг орон нутгаас хүлээн авах, дамжуулах, хяналт тавих, боловсруулалт хийх үйл ажиллагааг технологийн дагуу явуулах журмыг шинэчлэн баталж мөрдүүлэх;

6.2.9. хүн амын өсөлтийн хэтийн тооцоог олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа арга зүйд нийцүүлж өөрийн орны онцлогийг тусган боловсронгуй болгох;

6.2.10. нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн ойрын болон урт хугацааны тооцоонд тулгуурлаж загварчлал боловсруулах;

6.2.11. нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын хэмжээнд харьцуулсан динамик судалгаа хийж дүгнэдэг болох;

6.2.12. статистик судалгаа явуулах арга зүйн нэгдсэн заавар, зөвлөмж боловсруулж мөрдүүлэх.

6.3. Статистикийн арга зүй, судалгаа, шинжилгээг хөгжүүлэх дэд зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

6.3.1. судалгаа, шинжилгээний ажлын шинжлэх ухааны үндэслэл сайжирч, мэдээ, тооллого, судалгааны чанар, үр дүн, бодит байдал дээшилнэ;

6.3.2. албан ёсны статистикийн мэдээлэл, судалгааны үзүүлэлтүүдийн тодорхойлолт, тооцооны арга зүйг багтаасан үндэсний стандарттай болно.

### **Долоо. Статистикийн мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дэд зорилт**

7.1. Статистикийн мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дэд зорилт нь статистикийн мэдээлэл боловсруулалтын бүх үе шатанд өртөг, зардал багатай, шуурхай байдлыг хангасан техник, технологи нэвтрүүлэн төв, орон нутгийн статистикийн албадын техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн түвшний ялгааг арилгахад чиглэгдэнэ.

7.2. Статистикийн мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

7.2.1. статистикийн мэдээллийн нэгдсэн санг үе шаттайгаар байгуулж цахим сүлжээгээр хэрэглэгчдэд мэдээллийг хүргэдэг болох;

7.2.2. тоон үзүүлэлтийн тайлбар /мета/ мэдээллийн сан байгуулж статистикийн тооллого, судалгааны маягт зохиох, мэдээллийг боловсруулах, хадгалах, хэрэглэгчдэд хүргэх бүх үе шатанд ашиглах боломжийг бүрдүүлэх;

7.2.3. тооллого, түүвэр судалгааны мэдээлэл цуглуулахад бага оврын зөөврийн компьютерийг өргөнөөр ашиглах;

7.2.4. тайлан мэдээ, тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулахад Windows үйлдлийн системийн орчинд зохиосон программ хангамжийг ашиглах;

7.2.5. тооллого, түүвэр судалгааны мэдээллийг цахим технологи дээр суурилсан программ хангамжаар цуглуулах, боловсруулалт хийх, мэдээллийн санг автоматаар бүрдүүлэх боломж нөхцөлийг бий болгох;

7.2.6. статистикийн бүх шатны байгууллагын техникийн хүчин чадлыг өндөр түвшинд байлгаж сүлжээний найдвартай ажиллагааг хангах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалыг бүрэн хангасан техникийн болон программ хангамжтай болох зорилтыг үе шаттайгаар шийдвэрлэх;

7.2.7. статистикийн бүх шатны байгууллагын тоног төхөөрөмжийн 15 хувийг жил бүр шинэчлэх, шаардагдах хөрөнгийг тухайн жилийн улсын төсөвт тусгах;

7.2.8. "Цахим Монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа байгууллагатай хамтран ажиллаж аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны түвшинд статистикийн мэдээлэл боловсруулах техник, технологи, программ хангамжийг нэвтрүүлэх;

7.3. Статистикийн мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дэд зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

7.3.1. мэдээлэл боловсруулалтын түвшинг олон улсын жишигт хүргэнэ;

7.3.2. төв болон орон нутгийн статистикийн албадын техникийн хангамж, технологийн түвшний ялгааг арилж, орон нутагт статистикийн мэдээлэлд боловсруулалт хийх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах боломж бүрдэнэ;

7.3.3. статистикийн мэдээлэгч болон хэрэглэгч нь дэвшилтэт технологийг ашиглан

мэдээлэл дамжуулах, мэдээллийн санг ашиглах нөхцөл бүрдэнэ.

## Найм. Хүний нөөцийн удирдлагыг хөгжүүлэх дэд зорилт

8.1. Хүний нөөцийн удирдлагыг хөгжүүлэх дэд зорилт нь орчин үеийн удирдлагын менежментийг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлагыг сайжруулах, чадварлаг, тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчнийг төлөвшүүлэн мэргэшүүлэх замаар статистикийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын олон улсын стандартыг мөрдүүлэхэд чиглэгдэнэ.

8.2. Хүний нөөцийн удирдлагыг хөгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

8.2.1. статистикийн байгууллагын ажилтнуудыг орон сууцны болон нийгмийн хангамжийг дээшлүүлэх хөтөлбөрүүдэд хамруулан ажиллах нөхцлийг нь сайжруулах;

8.2.2. статистикийн байгууллагын ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээнд тавигддаг шаардлагыг өндөржүүлэх арга хэмжээ авах;

8.2.3. статистикийн мэдээлэлд судалгаа, шинжилгээ хийх, хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлсон загвар зохиох, прогноз хийх чадавхийг бий болгох;

8.2.4. өндөр хөгжилтэй орнуудад магистрантур, докторантурын сургалтад 1-2 ажилтанг жил тутам суралцуулах;

8.2.5. гадаадын өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд статистикийн мэргэжлээр оюутан суралцуулах;

8.2.6. статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, урт, богино хугацааны сургалтад хамруулах;

8.3. Хүний нөөцийн удирдлагыг хөгжүүлэх дэд зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

8.3.1. статистикийн ажилтнуудын ажлын бүтээмж нэмэгдэж, бүтээгдэхүүний чанар сайжран, хэрэглэгч үнэн бодитой, чанартай мэдээллээр хангагдана;

8.3.2. гадаад, дотоодод мэргэжилтэн бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх байнгын тасралтгүй тогтолцоо бүрдэж үндэсний мэргэшсэн боловсон хүчний нөөцтэй болно.

## Ес. Статистикийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх дэд зорилт

9.1. Статистикийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх дэд зорилт нь албан ёсны статистикийг боловсронгуй болгох, статистикийн үндэсний чадавхийг сайжруулахад чиглэсэн хоёр болон олон талт хамтын ажиллагааны идэвхтэй бодлого явуулахад чиглэгдэнэ.

9.2. Статистикийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.2.1. НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн идэвхтэй хамтран ажиллах;

9.2.2. олон улсын байгууллагуудаас статистикийн чиглэлээр зохион байгуулах хурал, чуулган, уулзалт болон бусад арга хэмжээнд оролцож, бүс нутгийн хэмжээнд идэвхтэй ажиллах;

9.2.3. олон улсын түвшинд техник туслалцааны хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, улс орнуудын засгийн газрын техникийн туслалцааны ЖАЙКА, ТИКА, ХБНГУ-ын ТХАБ, КОЙКА, АНУ-ын ОУХА зэрэг байгууллагуудтай холбоо тогтоон, техникийн туслалцаа авах боломжийг судлан эрх бүхий төрийн байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

9.2.4. уламжлалт харилцаатай орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн туршлагыг нь нэвтрүүлэх, мэдээлэл солилцох, олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрт хамрагдах боломжийг судалж хэрэгжүүлэх;

9.2.5. НҮБ-ын Статистикийн Хороо, Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн худалдааны байгууллага, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас зөвлөмж болгосон статистикийн жишиг үзүүлэлтүүд, тэдгээрийн ойлголт, тодорхойлолт, тооцооны арга зүйг үе шаттайгаар нэвтрүүлэх;

9.3. Статистикийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх дэд зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

9.3.1. статистикийн үзүүлэлтийн арга зүйг боловсронгуй болгох, хүний нөөц, техник, технологийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр гадны тусламж авах нөхцөл боломж бүрдэнэ;

9.3.2. статистикийн үйл ажиллагааны чиглэлээр олон улсын байгууллага болон гадаад орнуудтай тогтоосон харилцаанд

Монгол Улсын үүрэг оролцоо идэвхжин байр суурь бэхжинэ.

## Арав. Хөтөлбөрийн санхүүжилт

10.1. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөс бүрдэнэ.

10.2. Албан ёсны статистикийг хөгжүүлэх хөтөлбөрийг ойролцоогоор 12 тэрбум төгрөгийн хөрөнгөд багтаан хэрэгжүүлнэ.

## Арван нэг. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

11.1. Үндэсний статистикийн газар энэхүү хөтөлбөрийг төв, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

11.2. Статистикийн тухай хууль тогтоомж болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын тооллого, түүвэр болон иж бүрэн судалгааг зохион явуулна.

11.3. Статистикийн үйл ажиллагааны удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

11.4. Яам, агентлаг болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны статистикийн мэдээлэл, бүртгэл хариуцсан ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэн үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээ тайлангийн бодит байдлыг шалгахад туслах зорилгоор хяналт, сургалт, сурталчилгааны явуулын нэгжийг бий болгож бүс нутагт тогтмол ажиллуулна.

## Арван хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

12.1. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, олон улсын нийтлэг арга зүйгээр боловсруулсан, статистикийн мэдээллийн чанартай, шуурхай үйлчилгээ бий болно.

12.2. Статистикийн мэдээлэгч, хэрэглэгчдийн хоорондын харилцан итгэлцэл дээр тулгуурласан орчинд мэдээлэл авах, хэрэглэх нөхцөл бүрдсэнээр мэдээллийн хамралт сайжирч, үнэн зөв, бодит, шуурхай байдал хангагдана.

12.3. Статистикийн байгууллага нь шинжлэх ухаанд суурилсан алба болон бэхжинэ.

12.4. Олон улсын нийтлэг арга зүйг статистикийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, "ҮТС-93"-ыг үндэсний хэмжээнд бүрэн хэрэгжүүлснээр албан ёсны статистикийн хөгжил нь хөгжингүй орнуудын статистикийн түвшинд ойртоно.





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 27–ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын нөөц сангаас, дараагийн жилүүдэд гарах зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасуяй.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2006 онд гарах нэмэгдэл зардлыг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 03–ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

**Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэвийн нэмэгдэл олгоход шаардагдах зардлыг Санхүүгийн зохицуулах хорооны жил бүрийн төсөвт тусгаж байхаар тогтоосуяй.

1.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг хавсралтаар баталсуяй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 23 дугаар тогтоолын хавсралт*

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, ОРОН ТООНЫ ГИШҮҮНД ЗЭРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох асуудлыг зохицуулна.

2.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд Тэргүүн түшээ, Дэд түшээ зэрэг дэв олгоно.

3.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэв олгоход албан тушаал, төрийн алба хаасан хугацаа, урьд нь

олгогдсон зэрэг дэв, ажил хэргийн чадварыг харгалзана.

4.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүний зэрэг дэвийг Санхүүгийн зохицуулах хорооны санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно.

5.Тэргүүн түшээ зэрэг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар, Дэд түшээ зэрэг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингийн 23 хувиар тус тус тооцож, сар бүр олгоно.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 2 дугаар сарын 03–ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

**Тогтоолд нэмэлт оруулах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолын хавсралтын Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны

зэрэглэлийн ТӨ-VIA-д "Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн" гэсний дараа "Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн" гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2006 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

2006 оны 1 дүгээр сарын 26—ны өдөр	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 11	Улаанбаатар хот
<p style="text-align: center;"><b>Мөөгөний Жаргалд хошууч генерал цол хүртээх тухай</b></p>		
<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай Мөөгөний Жаргалд хошууч генерал цол хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн хүртээсүгэй.  <b>ЗАРЛИГ БОЛГОХ нь:</b></p>		
Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, Ар талын газрын дарга	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b>	Н.ЭНХБАЯР
2006 оны 1 дүгээр сарын 26—ны өдөр	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 12	Улаанбаатар хот
<p style="text-align: center;"><b>Ядмаагийн Чойжамцад хошууч генерал цол хүртээх тухай</b></p>		
<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай газрын дарга Ядмаагийн Чойжамцад хошууч хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн генерал цол хүртээсүгэй.  <b>ЗАРЛИГ БОЛГОХ нь:</b></p>		
Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, Энхийг сахиулах ажиллагааны	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b>	Н.ЭНХБАЯР
2006 оны 1 дүгээр сарын 26—ны өдөр	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 13	Улаанбаатар хот
<p style="text-align: center;"><b>Гонгорын Хайдавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай</b></p>		
<p>Соёл урлаг, боловсролын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж монгол улсад дуурийн урлаг болон мэргэжлийн дуулаачдыг бэлтгэх үндэс суурийг тавилцаж, дэлхийн сонгодог, үндэсний дуурийн олон дүр бүтээж, дуулаачдын залгамж хойч үеийг сурган хүмүүжүүлэх, орчин цагийн дуурийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа гарамгай хувь нэмрийг нь үнэлж</p>		
Соёл урлагийн их сургуулийн багш	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b>	Н.ЭНХБАЯР
Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.		
2006 оны 1 дүгээр сарын 26—ны өдөр	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 14	Улаанбаатар хот
<p style="text-align: center;"><b>Шаравын Шагдарт Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай</b></p>		
<p>Боловсролын байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгон газар зүйн дээд боловсролтой багш, мэргэжилтэн бэлтгэх, монгол улсад газар зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлст оруулж байгаа дорвитой хувь</p>		
нэмрийг нь үнэлж	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b>	Н.ЭНХБАЯР
"Газарчиг" дээд сургуулийн газар зүйн багш Шаравын Шагдарт Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.		
2006 оны 1 дүгээр сарын 26—ны өдөр	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 15	Улаанбаатар хот
<p style="text-align: center;"><b>Лэгшидийн Чуваамэдэд Монгол Улсын ардын зураач цол хүртээх тухай</b></p>		
<p>Мэргэжлийн урлагийн байгууллага болон боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж монголын уран сийлбэрийн уламжлалт аргыг хөгжүүлэн сэдэвт бүтээл, бэлэг дурсгал, эд хэрэглэл, барилга байгууламжийн олон сийлбэрийг мод, яс, эвэр, чулуугаар мэргэжлийн өндөр түвшинд урлан туурвиж монголын дүрслэх урлагийг</p>		
хөгжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж уран сийлбэрч	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b>	Н.ЭНХБАЯР
Лэгшидийн Чуваамэдэд Монгол Улсын ардын зураач цол хүртээсүгэй.		

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

### Түмэнбаярын Рагчаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Төр захиргааны төв байгууллагуудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж манай улсын хөдөө аж ахуй, худалдаа бэлтгэл, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, эх орны үйлдвэрүүдийг түүхий эдээр, хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангах үйлст оруулсан

хувь нэмрийг нь үнэлж Түмэнбаярын Рагчаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

### Бадрахын Сангажавт Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлийг мэргэжлийн удирдлагаар хангах, шинэ техник технологи нэвтрүүлэх, газар тариаланг сэргээн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Товхонхан" ХХК-ийн

ерөнхий захирал Бадрахын Сангажавт Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Ринченгийн Индрад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн их сургуульд багш, тэнхмийн эрхлэгч, декан, орлогч захирлаар он удаан жил үр бүтээлтэй ажиллаж хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрийн салбарт үндэсний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, хөдөө аж ахуйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ХААИС-ийн

Бүтээгдэхүүн судлалын тэнхмийн багш Ринченгийн Индрад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

### Цэдэнбалын Батсуурьт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгон багшлах боловсон хүчин бэлтгэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МУБИС-ийн дэд захирал

Цэдэнбалын Батсуурьт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### Нанзадын Цэндэд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Их, дээд сургуульд олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сургалтад шинэ технологи, шаталсан сургалтыг нэвтрүүлэх, менежментийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эдийн засагч, менежерийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Цэцэг гүн"

менежментийн коллежийн эрдмийн зөвлөлийн дарга, зөвлөх багш Нанзадын Цэндэд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

<p>2006 оны 1 дүгээр сарын 26–ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 21</p> <p align="center"><b>Дандарын Дашимаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай</b></p> <p>Соёл, урлагийн сургуулиудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгож, монгол улсад дээд боловсролтой дуулаачдыг бэлтгэх, дууны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Соёл, урлагийн их сургуулийн дуулаачийн багш Дандарын Дашимаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.</p>	<p align="right">Улаанбаатар хот</p> <p align="right"><b>Н.ЭНХБАЯР</b></p>
<p>2006 оны 1 дүгээр сарын 26–ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 22</p> <p align="center"><b>Жадамбын Пүрэвжавт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай</b></p> <p>Төв, хөдөөгийн ерөнхий боловсролын сургуульд багш, хичээлийн эрхлэгч, захирлаар олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, сурагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн 11 жилийн "Эхлэл" дунд сургуулийн сургалтын менежер Жадамбын Пүрэвжавт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.</p>	<p align="right">Улаанбаатар хот</p> <p align="right"><b>Н.ЭНХБАЯР</b></p>
<p>2006 оны 1 дүгээр сарын 26–ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 23</p> <p align="center"><b>Лувсаннъямын Гавалмаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай</b></p> <p>Ерөнхий боловсролын сургуульд олон жил санаачилга, үр бүтээлтэй багшилж заах аргын үр чадвар, сургалтын чанарыг дээшлүүлж, өсвөр үеийнхнийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн 11 жилийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш Лувсаннъямын Гавалмаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.</p>	<p align="right">Улаанбаатар хот</p> <p align="right"><b>Н.ЭНХБАЯР</b></p>
<p>2006 оны 1 дүгээр сарын 26–ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 24</p> <p align="center"><b>Сандагийн Лхагвадоржид Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай</b></p> <p>Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээний шинэ аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлэн, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, уламжлалт монгол эмнэлгийг үүсгэн байгуулж хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дорнод аймгийн Уламжлалт монгол эмнэлгийн эрхлэгч, их эмч Сандагийн Лхагвадоржид Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.</p>	<p align="right">Улаанбаатар хот</p> <p align="right"><b>Н.ЭНХБАЯР</b></p>
<p>2006 оны 1 дүгээр сарын 26–ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b> Дугаар 25</p> <p align="center"><b>Балдандоржийн Төмөрт Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай</b></p> <p>Урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж цэрэг, эх орны болон аж байдлын сэдэвтэй монгол ардын, зохиолын дуунуудыг чадварлаг дуулж, олон шилдэг шавь бэлтгэн монголын нийтийн дууны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дуучин Балдандоржийн Төмөрт Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.</p>	<p align="right">Улаанбаатар хот</p> <p align="right"><b>Н.ЭНХБАЯР</b></p>



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

### Дашзэвэгийн Галсантогтоход Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж авъяас, үр чадвараа хөгжүүлэн ардын урлагийн өв сангаас байнга суралцаж монгол ардын урт, богинын дуунуудыг лимбэ, аман хуур хөгжмөөр чадварлаг хөгжимдөж ард түмэндээ урлагаар үйлчлэх үйлст

оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж хөгжимчин Дашзэвэгийн Галсантогтоход Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

### Чимэдийн Гомбод Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн өндөр үр чадвар эзэмшин баримтат болон уран сайхны, телевизийн олон киноны зохиол бичиг, найруулж туурвин, монголын кино урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

кино зохиолч, найруулагч Чимэдийн Гомбод Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### Баяраагийн Наранбаатар, Цогтбазарын Энхжаргал нарт Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Бөхийн чөлөөт барилдааны төрлөөр дэлхий, тив, олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцож, 2005 оны дэлхийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл медаль хүртэж, эх орныхоо нэр алдрыг дуурсгасан гавьяаг нь үнэлж бөхийн чөлөөт барилдааны үндэсний шигшээ багийн тамирчин

Баяраагийн Наранбаатар, Цогтбазарын Энхжаргал нарт Монгол Улсын гавъяат тамирчин цол тус тус хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, мэргэжлийн хяналт, татвар, эрчим хүч, уул уурхай, төр

захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Очирын Баатар - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн өндөр настан, судлаач
2. Дамбын Базаргүр - ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
3. Ганхүүгийн Батбаяр - Дархан-Уул аймгийн Хүүхдийн төлөө төвийн дарга
4. Гүүширийн Далайжамц - Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн

5. Алтангэрэлийн Дамбадаржаа - Нийслэл дэх хамгаалалтын албаны "Бүрэнбамбай" ХХК-ийн захирал
6. Гончигийн Даш - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Тунгалаг-Эрдэнэ" ХХК-ийн дэд захирал
7. Намсрайн Долгорхүү - ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургуулийн салбарын эрхлэгч

8. Загдын Лханаа - Нийслэлийн Баянгол дүүрэг дэх "Эв нэгдэл" СӨХ-ны гүйцэтгэх захирал
9. Нэрэнгийн Сүхбаатар - Нийслэлийн хөдөө аж ахуйн "Их дүүрэн" хоршооны эзэн, малын эмч
10. Дашдондогийн Цогзол - Монголын Үндэсний бөхийн холбооны цолчин, засуул

11. Жавзангийн Цолоо - ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан
12. Өлзийбадрахын Чимэдрдорж - Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын газар тариалангийн "Атартрейд" ХХК-ийн ерөнхий захирал
13. Шаравын Чунаг - ШУА-ийн орлогч дарга

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Галсанбалдангийн Аахүү - "Орчлон фильм" кино студийн зургийн дарга
2. Ойдовын Адъяа - ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн секторын эрхлэгч
3. Нямаагийн Алтанцэцэг - Нийслэлийн Налайх дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвийн бүжгийн багш
4. Содномын Алтанцэцэг - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 11 жилийн 62 дугаар сургуулийн бага ангийн багш
5. Нацагдоржийн Ариунгуа - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн хятад судлалын секторын эрхлэгч
6. Үржингийн Арслан - "Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн тэргүүн дэд захирал
7. Жамбалын Асалбай - Чөлөөт уран бүтээлч
8. Дэлэгийн Аюур - Дундговь аймгийн Сайнцагаан сумын 5 дугаар сургуулийн бага ангийн багш
9. Цэрмаагийн Байгалмаа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор сургуулийн бага ангийн багш
10. Өвгөнхүүгийн Балдандугар - Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Долоод багийн малчин
11. Должидын Басхүү - Мэдээлэл технологийн үндэсний паркийн албаны дарга
12. Дариймаагийн Батмөнх - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны өндөр настан, ахмад багш
13. Сэндэнгийн Батмөнх - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засвар механикийн заводын ган хайлагч
14. Цэвээнравдангийн Батнасан - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 17 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
15. Авирмэдийн Бат-Очир - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын "Дулаан шарын гол" ОНӨҮГ-ын хэсгийн дарга
16. Жасрандоогийн Батсүх - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
17. Авирмэдийн Баян-Эрдэнэ - Говь-Алтай аймгийн Барилгын үйлдвэрлэлийн "Орд Харш" ХХК-ийн инженер
18. Чойжилын Баяраа - Монголын үндэсний телевизийн зураглаач
19. Нацагдоржийн Баярхүү - Баянхонгор аймгийн "Монголболгаргео" ХХК-ийн Дөвөнт алтны уурхайн дарга

20. Түнтүүшийн Болд - Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-ын дарга
21. Цэрэнжавын Будханд - Улсын Клиникийн төв эмнэлгийн нөхөн сэргээх эмчилгээний тасгийн гар заслын эмчилгээний зөвлөх
22. Жигжидсүрэнгийн Бямбасүрэн - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Өмчийн харилцааны газрын санхүүгийн улсын байцаагч
23. Сандуйжавын Даваасамбуу - Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн арилжаа судалгааны албаны захирал
24. Бадрахын Даваасүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 жилийн 28 дугаар сургуулийн бага ангийн багш
25. Жүгдэрийн Дарамсүрэн - UBS, ТВ-9 телевизийн орчуулгын киноны жүжигчин
26. Зундуйн Дашдэндэв - Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналтын улсын байцаагч
27. Очирын Долгор - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн гэрээний багш
28. Доржпаламын Дорж - ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
29. Дарьсүрэнгийн Дэмбэрэлдорж - Орхон аймгийн "Монгол судар" ХХК-ийн редактор, зохиолч
30. Шандангийн Дэнсмаа - Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх "Баянзүрх" эмнэлгийн дэд захирал
31. Баасанжавын Жамцай - Эрчим хүчний зохицуулах газрын мэргэжилтэн
32. Бүдширийн Загдга - Баянхонгор аймгийн "Монголболгаргео" ХХК-ийн Дөвөнт алтны уурхайн дизельчин
33. Амьтаны Идэр - Дорнод аймгийн Баянтүмэн сумын татварын улсын байцаагч
34. Сүрэнхорлоогийн Ичинхорлоо - Дорнод аймгийн ЗДТГ-ын иргэний бүртгэл мэдээллийн албаны мэргэжилтэн
35. Даваанямын Лхагва - Булган аймгийн Хутаг-Өндөр сумын 11 жилийн сургуулийн захирал
36. Рэгзэнгийн Лхагвасүрэн - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн чанар хяналтын хэлтсийн лаборант
37. Балданжамцын Маамхүү - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн өндөр настан, ахмад багш
38. Равжирын Мажигсүрэн - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын иргэн, ахмад багш

39. Наваанжамъянгийн Мижиддорж - Хөвсгөл аймгийн Гандандаржаалин хийдийн жасын нэрв
40. Дамчаагийн Молом - Ховд аймгийн Чандмань сумын малчин
41. Түвдэнгийн Молотов - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Чин Модун" ХХК-ийн захирал
42. Самдангийн Мөнхтэгш - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн төмөр замын цехийн дарга
43. Үлэмжийн Мөнгөнхүү - Улсын Клиникийн нэгдүгээр амаржих газрын бага эмч
44. Мөрийн Навган - Дорноговь аймгийн Ахмадын хорооны дэргэдэх "Өртөө ус" хоршооны дарга
45. Дагвын Нансалмаа - ШУТИС-ийн Хүнс биотехнологийн сургуулийн захирал
46. Насанбаярын Нэргүйбаатар - МУТВ, ТВ-9 телевизийн орчуулгын киноны жүжигчин
47. Бархасын Нямхүү - Баянхонгор аймгийн "Монголболгаргео" ХХК-ийн Дөвөнт алтны уурхайн геологийн инженер
48. Равжаагийн Оюун - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 жилийн 17 дугаар сургуулийн орос хэлний багш
49. Намсрайн Пүрэвжав - Ховд аймгийн Дөргөн сумын Агваш багийн малчин
50. Пүрэвийн Пэлжид - Монгол Чехословакийн хамтарсан геологи, уул уурхайн "Монгол-чехословакметалл" хамтарсан үйлдвэрийн ерөнхий нягтлан бодогч
51. Шийлэгийн Пэлжид - Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Ачлахуй" өрхийн эмнэлгийн сувиллагч
52. Мишигдоржийн Рэгзэнбал - Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын харьяа Улс төрийн хэлмэгдэгсдийн судалгааны төвийн шинжээч
53. Дамирангийн Самданям - Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилалын бариа заслын бага эмч
54. Батбаярын Сүрэн - Төв аймгийн Сэргэлэн сумын албан бус боловсролын багш
55. Дамчаагийн Сүхбат - Ховд аймгийн Чандмань сумын малчин
56. Санжмятавын Сүхбат - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн монгол зургийн багш
57. Гэндэнгийн Сэлэнгэ - Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч
58. Гочоогийн Сэрээтэр - Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш
59. Готовын Тойвгой - Баянхонгор аймгийн Баянлиг сумын малчин
60. Пүрэвийн Төмөртогтох - Кино урлагийн дээд сургуулийн багш
61. Үржиндоржийн Төмөрхуяг - Дорнод аймгийн "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ХК-ийн гүйцэтгэх захирал
62. Чүлтэмийн Туяа - Ховд аймгийн Хөгжимт драмын театрын зохион байгуулагч
63. Нацагдоржийн Туяацэцэг - "Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал
64. Чулууны Үүлэнсолонго - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн клиник-биохимийн лаборант
65. Дугарсүрэнгийн Хундагаа - Нийслэлийн барилгын хийц эдлэлийн "Бетон-Арматур" ХХК-ийн ерөнхий захирал
66. Мухамадигийн Хурметхан - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
67. Даваацэрэнгийн Хүрлээ - Орхон аймгийн "Эрдэнэт дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн дулааны шугам сүлжээний цехийн дарга
68. Дамбарэнцэнгийн Хүрэлхүү - Нийслэлийн соёл урлагийн "Эй Би Экс интернейшнл" ХХК-ийн Шинэ үе продакшнний жүжигчин
69. Наваандоогийн Цогт - МУБИС-ийн Биеийн тамирын дээд сургуулийн спорт тоглоомын багш
70. Базарсадын Цогтсайхан - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засвар-механикийн заводын дарга
71. Жагванжавын Цэен-Ойдов - ШУТИС-ийн Эрчим хүчний инженерийн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
72. Тавхайжамцын Цэмпилмаа - МУТВ, ТВ-9 телевизийн орчуулгын жүжигчин
73. Сүрэнгийн Цэнд - Дундговь аймгийн Сайнцагаан сум дахь хүнсний үйлдвэрлэлийн "Говийн тэнгэр" ХХК-ийн худалдагч
74. Зундуйн Цэндсүрэн - Сэлэнгэ аймгийн Дулаанхаан тосгоны өндөр настан, ахмад багш
75. Бүдрэгчаагийн Чимиддорж - Чөлөөт уран бүтээлч
76. Сандуйжавын Чимэддорж - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 11 жилийн 1 дүгээр сургуулийн математикийн багш
77. Цагааны Чулуунцэцэг - Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн бага эмч
78. Цэдэнгийн Шинэн - Баянхонгор аймгийн Баянлиг сумын малчин
79. Нүүдэлийн Шуурай - Дорнод аймгийн Баянтүмэн сумын ЗДТГ-ын Төрийн сангийн төлөөлөгч
80. Батаагийн Энхжаргал - МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн багш
81. Очирын Эрдэнэтуяа - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирлын үйлдвэрлэл эрхэлсэн орлогчийн хөдөлмөр хамгаалал ба байгаль орчны асуудал хариуцсан орлогч

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дарийн Адъяа - Хүнсний Технологийн коллежийн тоног төхөөрөмжийн багш
2. Мустафагийн Алей - ШУТИС-ийн Геологийн сургуулийн багш
3. Бацдийн Алтан-Ай - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 жилийн 93 дугаар сургуулийн сургалтын менежер
4. Лэгдэнгийн Алтанцэцэг - Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-ын нягтлан бодогч
5. Бүдийн Ариунаа - Нийслэлийн ШУА-ийн тэргүүлэгчдийн газрын бичээч-бичиг хэргийн эрхлэгч
6. Галсангийн Ариунболд - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Шилмэл гоёл" хоршооны алт мөнгөний дархан
7. Цамбажавын Баатар - Орхон аймгийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч
8. Дугарын Бааст - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч
9. Түндэвийн Бадам - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хорооны өндөр настан, ахмад жолооч
10. Цэрэнжамцын Базарваань - Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын малчин
11. Гомбожавын Бат-Очир - Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэн Баян-Улаан багийн малчин
12. Бямбын Батцэнгэл - Монгол Чехословакийн хамтарсан геологи, уул уурхайн "Монгол-чехословакметалл" хамтарсан үйлдвэрийн ерөнхий менежер
13. Шаравпэлжээгийн Баярсайхан - Нийслэлийн соёл урлаг, аялал, жуулчлалын "Соёмбо продакш энд Трэвел" ХХК-ийн Соёмбо кино театрын тоног төхөөрөмжийн техникч
14. Ядамсүрэнгийн Баярхүү - Хүнсний Технологийн коллежийн багш, тэнхимийн эрхлэгч
15. Пүрэвийн Болд - ШУТИС-ийн Барилгын инженерийн сургуулийн багш
16. Лувсангомбын Бум-Эрдэнэ - Нийслэлийн нийтийн тээврийн "Хос-Өлзий" ББН-ийн жолооч
17. Энхбатын Буянмандах - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга
18. Хүүхээгийн Бүдхүү - Соёлын дээд сургуулийн хөгжмийн багш, тэнхимийн эрхлэгч
19. Дарамын Бямбадоо - Баянхонгор аймгийн "Монголболгаргео" ХХК-ийн Девонт алтны уурхайн бульдозерчин
20. Базаргачийн Гаяя - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн "Сүхбаатар" эрүүл мэндийн нэгдлийн их эмч
21. Нохойжавын Ганбаатар - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын ахлах байцаагч
22. Гүрдоржийн Гансүх - Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Өлзийт" хоршооны дарга
23. Бэгзийн Даваажав - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 11 жилийн 62 дугаар сургуулийн биеийн тамирын багш
24. Намнангийн Дайрйимаа - Нийслэлийн Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэгийн багш
25. Лувсандоржийн Дамба - "Хот байгуулалт" ТӨҮГ-ын жолооч
26. Лувсанцэрэнгийн Дамдинсүрэн - ШУТИС-ийн Барилгын инженерийн сургуулийн зураг зүйн багш
27. Содномжамцын Дамдинсүрэн - МоАХ-ны хэвлэл мэдээллийн албаны дарга
28. Базаррагчаагийн Дарйимаа - Нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн амбулаторийн мэдрэлийн их эмч
29. Цэрэнгийн Дарйимаа - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Алткин" ХХК-ийн САПУ үйлдвэрийг хариуцсан дэд захирал
30. Пүрэвжавын Дарин-нулуун - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн мах боловсруулах заводын хэсгийн дарга, лабораторийн эрхлэгч
31. Должингийн Даш - ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
32. Тунгалагийн Дашнанжид - Хөвсгөл аймгийн хүнсний үйлдвэрлэлийн "Сонголт" ХХК-ийн нягтлан бодогч
33. Нацагийн Дондогбазар - Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дэргэдэх "Баянгол" сургалтын төвийн эрхлэгч
34. Сумъяагийн Ендонпил - Баянхонгор аймгийн "Монголболгаргео" ХХК-ийн Девонт алтны уурхайн ахлах мастер
35. Ширнэнгийн Жадамбаа - ШУТИС-ийн Хүнс биотехнологийн сургуулийн багш
36. Ширнэнгийн Жамбал - Хүнсний Технологийн коллежийн багш
37. Ядамдоржийн Жигжид - Монгол Чехословакийн хамтарсан геологи, уул уурхайн "Монгол-чехословакметалл" хамтарсан үйлдвэрийн жолооч
38. Баатарбалын Кумаа - Нийслэлийн Баянгол дүүргийн "Баянгол" Эрүүл мэндийн нэгдлийн эмчилгээ эрхэлсэн орлогч
39. Цэрэндуламын Лааганжав - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засвар механикийн заводын үйлдвэр техникийн хэлтсийн дарга
40. Сэдбайдарын Лхаасүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагч
41. Дашзэвэгийн Лхагвасүрэн - Нийслэлийн Сүхбаатар дүүрэг дэх "Сонор" бизнес мэдээллийн төвийн цаг засварчин
42. Оргийн Лхамсүрэн - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн өндөр настан, төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан



43. Доржийн Лхамхүү - Нийслэлийн Хан-Уул дүүргийн өндөр настан, "Гэрэлтүүлэг чимэглэл" ХК-ийн ахмад ажилтан

44. Лэгзэнгийн Мигжин - Ховд аймгийн Дөргөн сум дахь "Амгаланг үүсгэгч Майдарын гэгээний хийд" - ийн тэргүүн агина

45. Доржийн Мэндбаяр - Нийслэлийн Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэгийн багш

46. Санжаагийн Мягмар - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Химийн төв лабораторийн дарга

47. Дамбийнамын Мягмарсүрэн - Дундговь аймгийн Сайнцагаан сум дахь хүнсний үйлдвэрлэлийн "Говийн тэнгэр" ХХК-ийн худалдагч

48. Дашцэрэнгийн Мягмарсүрэн - Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын албаны их эмч

49. Пүрэв-Очирын Мягмарсүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 11 жилийн 12 дугаар сургуулийн зураг, технологийн багш

50. Цүлтэмийн Нармандах - Дүрслэх урлагийн дээд сургуулийн монгол зургийн багш, тэнхимийн эрхлэгч

51. Чулууны Нацагдорж - ШУТИС-ийн Эрчим хүчний инженерийн сургуулийн тэргүүлэх профессор

52. Зундуйжамцын Нацагсүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 101 дүгээр цэцэрлэгийн багш

53. Дугарсүрэнгийн Отгон - Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-ын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга

54. Балдан-Осорын Отгонгэрэл - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Хар хорин хүрээ" ХХК-ийн ерөнхий захирал

55. Жалбуугийн Оюунбилэг - "Хот байгуулалт" ТӨҮГ-ын зургийн ахлах техникч

56. Дашдамбын Оюуннаран - ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн лаборант

57. Болдын Оюунчимэг - Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн их эмч

58. Даваахүүгийн Пүрэвсүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн газрын албаны газар зохион байгуулагч

59. Дамдинсүрэнгийн Сарантуяа - Нийслэлийн Баянгол дүүргийн сургалт үйлдвэрлэлийн "Сэтгэмж" цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

60. Дагвадоржийн Содовжамц - Нийслэлийн "Гэрэлтүүлэг чимэглэл" ХК-ийн ахмадын зөвлөлийн дарга

61. Уртнасангийн Сувдсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн газрын албаны төлбөрийн байцаагч

62. Дашийн Сумбаа - Сэлэнгэ аймгийн Орхон сумын ЗДТГ-ын жолооч

63. Лувсаншаравын Сумъяа - Дорнод аймгийн Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн серологич их эмч

64. Гомбосүрэнгийн Сүхбаатар - Монгол Сингапурын хамтарсан гэрэл зургийн "Жи-Эй-Жи" ХХК-ийн техникийн албаны инженер

65. Цэдэнгийн Сүрэнжав - Орхон аймгийн "Эрдэнэт дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн дулааны хяналтын инженер

66. Надмидцэдэнгийн Сүхчулуун - Нийслэлийн Газрын албаны дүүрэг хариуцсан газар зохион байгуулагч

67. Чүлтэмийн Сэржим - Н и й с л э л и й н Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны хэсгийн ахлагч

68. Сүхийн Төмөрдулам - Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг теслийн хүрээлэнгийн мэдээллийн сангийн мэргэжилтэн

69. Лхамсүрэнгийн Тунгалаг - Соёлын дээд сургуулийн сургалтын албаны эрхлэгч

70. Рашбудын Тунгалаг - Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн зөвлөх их эмч

71. Дашзавын Үржинбадам - Ардчилсан намын Ахмадын холбооны нарийн бичгийн дарга

72. Нанзаддоржийн Цагаанцоож - ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

73. Гаравын Цацрал - Улсын мэргэжлийн хяналтын албаны нэгдсэн төв лабораторийн лаборант

74. Сугирзавын Цэдэв - Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Мандах багийн малчин

75. Ойдовын Цэдэн - "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн цахилгааны инженер

76. Гомбын Цэндмаа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн "Буянт-Ухаа" цогцолбор сургуулийн бага ангийн сургалтын менежер

77. Цэдэвийн Цэндмаа - " М о н г о л ы н хөрөнгийн бирж" ХК-ийн бүртгэл хяналтын албаны захирал

78. Чойжилжавын Цэрэндолгор - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ харууцсан орлогч

79. Гомбосүрэнгийн Цэцэгээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны "Цэдэн-Эрдэнэ" өрхийн эмнэлгийн өрхийн эмч

80. Гэндэнжамцын Цэцэгээ - Хүнсний Технологийн коллежийн онылон багш

81. Шаравын Цэцэгмаа - " Д у л а н ы цахилгаан станц-2" ХК-ийн турбины машинч

82. Бадамжавын Цэцэгмаа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 жилийн 17 дугаар сургуулийн орос хэлний багш

83. Алтангэрэлийн Чимэгсайхан - ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн референт

84. Майдарын Чимгээ - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн "Сүхбаатар" эрүүл мэндийн нэгдлийн өрөнхий мэргэжилтэн

85. Ренчингийн Чогжмаа - МУИС-ийн Гадаад оюутны байрны ажилтан, МАН-ын 16 дугаар үүрийн дарга

86. Базаррагчаагийн Энхбаяр - Нийслэлийн брокер диллерийн "Санар" ХХК-ийн гүйцэтгэх захирал

87. Гочоогийн Энхболд - "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн слесарь

88. Дацдаваагийн Энэжаргал - "Үют цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

89. Шагдарсүрэнгийн Энхцэцэг - Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн мэдээллийн төвийн дарга

90. Сүхбаатарын Эрдэнэбат - Баянхонгор аймгийн "Монголболгаргео" ХХК-ийн Дөвөнт алтны уурхайн засварчин

91. Шарын Эрдэнэчимэг - Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-ын иргэний бүртгэл мэдээллийн ажилтан

## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

Базаргочоогийн Бат-Амгалан - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн

ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 2/01

Улаанбаатар хот

### Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зорчсон эсэх тухай маргааны хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Л.Рэнчин, П.Очирбат, Ж.Амарсанаа /илтгэгч/, Ч.Дашням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяа нарыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч З.Энхболд, өргөдөл гаргагч иргэн Ц.Банзрагч, Б.Үнэнбат нар оролцлоо.

**Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 12 дугаар хорооны оршин суугч, иргэн Ц.Банзрагч, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Үнэнбат нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:**

"Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2-ын ".../Ерөнхий сайд/..." гэсэн хэсэгт Монгол Улсын Засгийн газраас гаргасан захиргааны актыг Захиргааны хэргийн шүүх магадлан хянаад, тус хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн" гэсэн 38 дугаар зүйлийн 1, "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зорчиж байгаа үндэслэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд,

"Монгол Улсын төрийн байгуулал" гэсэн Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэгт төрийн эрх мэдлийг Улсын Их Хурал /хууль тогтоох/, Засгийн

газар /гүйцэтгэх/, Шүүх эрх мэдэл гэсэн хуваарийн дагуу эрх мэдлийн салаа мөчир болгон тус тусад нь бүрэн эрхийг зааглан тодорхойлсон. Энэхүү хуваарилалт нь эрх мэдлийн салаа мөчир бүрт Үндсэн хуулиар хязгаарлалт тогтоож буйн илэрхийлэл бөгөөд эрх мэдлүүд нь бие биенээ тэнцвэржүүлж, улс төр, эрх зүйн хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд ямар нэгэн логик зөрүү үүсэхгүйгээр зохион байгуулагдах ёстой гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэж заасан нь Засгийн газрын шийдвэр болох Ерөнхий сайдын захирамжийг хүчингүй болгох эрх бүхий байгууллагыг шууд тодорхойлсон заалт бөгөөд үүнтэй адил зохицуулалтыг Үндсэн хуулийн бусад зүйл, заалтуудаас харж болно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно", мөн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно" гэжээ.

Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх гэсэн Үндсэн хуулийн байгууллагууд буюу эрх мэдлийн харилцан зааг хязгаар, эрх хэмжээ, хариуцлагыг Үндсэн хуульд хуульчлан тогтоож өгсөн заалт юм.

Дээрх байдлыг нотлон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.1, 4.1.6 нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь

хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлт гаргаж, улмаар уг хуулинд Улсын Их Хурал өөрчлөлт оруулжээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь хэсгийн ".../Ерөнхий сайд/..." гэсэн нь мөн хуулийн 4.1.1 дэх /Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаас хүчингүй болгосон/ хэсгийн заалтын нэгэн адил Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалттай нийцэхгүй байгаа тул Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь заалтын ".../Ерөнхий сайд/..." гэснийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна" гэсний дагуу захирамжид Ерөнхий сайд, сайд гарын үсэг зурж баталгаажуулдаг хамтын шийдвэр бөгөөд Ерөнхий сайдын захирамж нь Засгийн газрын шийдвэр юм.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д "...Засгийн газрын шийдвэр...", мөн Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд "...Засгийн газрын шийдвэр..." гэж тус тус заасан бөгөөд зарим маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхдээ Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол сүүлийн үед гарах болсон нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуулинд нийцээгүй, ... хуулийг хэрэглэх эрхгүй" гэсэн заалт мөн адил зөрчигдөхөд хүргэж байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, үндэслэлүүдийг харгалзан үзэж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2-т тусгагдсан ".../Ерөнхий сайд/..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй тус тус зөрчилдөж байгааг хянан үзэж, Үндсэн хуульд нийцүүлэх талаар дүгнэлт гаргаж өгөхийг хүсье" гэжээ.

**Хоёр. Иргэн Ц.Банзрагч, Б.Үнэнбат нар 2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан дээр гаргасан нэмэлт тайлбартаа:**

1. Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д зааснаар Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг тусгайлан тогтоосон. Улсын Их Хурал, Засгийн газар энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн

хуулийн цэцэд хандаж шийдвэр шийдвэрлүүлж болох нь нээлттэй.

Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянахаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан хэрэг болж байна. Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянан эрх хэмжээг Үндсэн хуулиар олгоогүй гэж үзэж байна.

Ер нь, төрийн дээд байгууллагуудын шийдвэрийн халдашгүй байдлын хүрээ буюу "дархлаа" гэж байдаг. Засгийн газар нь шийдвэрээ хууль биелүүлэх зорилгоор хуульд нийцүүлэн гаргадаг ба тэр нь тодорхой хувь иргэнд шууд чиглэх биш улс орны тодорхой хүрээ, салбарт үйлчлэхээр гардаг. Тэр утгаараа Засгийн газар, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч зэрэг байгууллагын шийдвэрийн дархлаа, баталгаа нь нийтийн ашиг сонирхол байдаг. Хэрэв Засгийн газар үнэхээр хууль тогтоомжид нийцэхгүй шийдвэр гаргавал Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийнхээ дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, улс төрийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн "1. Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2. Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана" гэснээр тодорхойлогдож байна. Тэрчлэн Ерөнхий сайд тодорхой хувь этгээдийн ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэр гаргадаггүй нь "Ерөнхий сайдын бүрэн эрх" гэсэн Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлээс тодорхой байгаа билээ.

2. Засгийн газрын шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй гэж иргэн, хуулийн этгээд үзвэл Засгийн газарт өөрт нь, эсхүл Улсын Их Хурлын гишүүнд буюу шууд Улсын Их Хуралд өөрт нь хандан шийдвэрлүүлэх эрх Үндсэн хууль, бусад хуулиар иргэдэд нээлттэй юм. Хэрэв хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох эрхийг Улсын Их Хуралд хүлээлгэсэн байна. Үүнээс гадна, Засгийн газар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг үндэслэн Засгийн газрын хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг Үндсэн хуулийн цэцэд хандан шүүхийн журмаар шийдвэрлүүлэх боломжтой юм.

3. Монгол Улсын иргэн Засгийн газрын хууль бус шийдвэрийн талаар Засгийн газар, Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэц /Цэц өөрөө шүүх/-д гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй байгаа тул Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүхлэх эрх хязгаарлагдсан гэдгийг зөвшөөрөх боломжгүй байна, нөгөө талаас, бидний өргөдлийн агуулга нь эл үндсэн эрхийг хязгаарласан тухай биш, харин

Засгийн газрын шийдвэрийг Үндсэн хуулиас гадуур журмаар хүчингүй болгох эрхийг захиргааны шүүхэд олгосон тухай асуудал юм.

4. Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна" гэж зааснаас харахад Ерөнхий сайдын захирамж нь хамтаар гаргаж буй Засгийн газрын шийдвэр юм.

**Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Эрхэн Их Хурлын гишүүн З.Энхболд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дэх хэсгийн "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа, хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна.

Өргөдөл гаргагч нар өргөдөлөө төрийн эрх мэдлийг хууль тогтоох /Улсын Их Хурал/, гүйцэтгэх /Засгийн газар/, шүүх эрх мэдэл гэсэн салаа мөчирт хуваарилан тодорхойлсон талаар дурдахдаа шүүх эрх мэдлийг засгийн гурван салааг хооронд нь тэнцвэржүүлэгч хүч болдог талаар анхаарахыг хүссэнгүй.

Захиргааны аливаа байгууллага зөвхөн хуулиар олгосон бүрэн эрхийн дотор шийдвэр гаргаж байна. Харин хүний эрхийн хүрээнд хөндлөнгөөс оролцож, хуулийг өөрчилж ч, зөрчиж ч болохгүй юм.

Ийнхүү дэлхийн улс орнуудад захиргааны шүүхээс захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд /хөндлөнгийн/ шүүхийн хяналт тогтоож, хэрэг маргааныг шийдэж, улмаар хүний эрхийг хамгаалах, байгууллага, албан тушаалтнаас хууль ёсыг сахин биелүүлэхэд чиглэсэн механизм болгох явдал түгээмэл байна. Шүүхийн хяналт бол захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай процессийн эрх зүйн хэлбэр мөн бөгөөд ийнхүү хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын /ног талаас гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нөгөө талаас иргэн, хуулийн этгээд/ тэгш байдлыг хангаж байна.

Практик дээр иргэний гаргасан гомдлын дагуу Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байсан тохиолдол нэг ч гараагүй болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу иргэн, хуулийн

этгээд нь захиргааны хууль бус гэж үзэж байгаа актын талаархи нэхэмжлээс захиргааны хэргийн шүүхэд гаргахын өмнө гомдлоо тухайн байгууллага, албан тушаалтныг харъяалах дээд шатны байгууллага, албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлүүлж байхаар хуульчилсан билээ. Улсын Их Хурал нь гомдол, маргаан хянан шийдвэрлэдэг байгууллага биш учраас иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг хянан барагдуулах боломжгүй юм.

2. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн "төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй", мөн зүйлийн 14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх эрхтэй" гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын "Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй" гэсэн наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын "Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй..." гэсэн хорин зургадугаар зүйлийн заалтуудыг баримтлан Монгол Улсын Ерөнхий сайдаас гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг захиргааны хэргийн шүүхээс хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан билээ.

Хэрэв Монгол Улсын Ерөнхий сайдаас гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн байдал нь тохирохгүй гэж үзэж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасныг баримтлан Улсын дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй билээ.

3. Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу "Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ" ... үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ. Танхимын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Засгийн газрын хуралдаан мөн".

Мөн Үндсэн хуулийн Дөчинтавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргана", Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд "Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана" гэж тус тус заажээ. Үүнээс үзэхэд Ерөнхий сайдын захирамж заавал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлаар гарах шаардлагагүй байна.

Өөрөөр хэлбэл Ерөнхий сайдын захирамж нь нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны албан тушаалтнаас бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр/захиргааны акт/ болж байна. Иймд иргэн, хуулийн этгээд хууль бус захиргааны акттай холбоотой нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргаж зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулна” гэжээ.

## ҮНДЭСЛЭЛ:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан “/...Ерөнхий сайд.../” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1; Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй болох нь дор дурдсан үндэслэлээр тогтоогож байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гаргасан 2/02 дугаар дүгнэлтдээ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан” гэсэн 4 дүгээр зүйлийн “...дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн 1 дэх хэсгийн 4.1.1-д “Монгол Улсын Засгийн газар” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна” гэж заажээ.

2. Дээрх дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-ийн “Монгол Улсын Засгийн газар” гэснийг хүчингүй болгосон байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1-д “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах...”, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д

“Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана” гэж заажээ.

4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын тухай хууль болон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн холбогдох заалт ёсоор Засгийн газрын шийдвэрт тогтоол, захирамжийг хамааруулан ойлгоно.

5. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-ын “/...Ерөнхий сайд.../” гэсэн заалтад уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5, 3.1.6 дахь заалт нэгэн адил хамаарч байна. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд эрх хэмжээнийхээ хүрээнд захирамжаас гадна амаар буюу бичгээр захиргааны акт, мөн түүнчлэн эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ /үйлдэл, эс үйлдэхгүй/-г явуулж болохоор хуульчилсан тул дээрхи хуулийн 4.1.2-т заасан “/...Ерөнхий сайд.../” гэснийг хүчингүй болгох үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг удирдлага болгон

## ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “/...Ерөнхий сайд.../” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1; Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хонгог багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГА  
ГИШҮҮД**

**Ж.БЯМБАДОРЖ  
Л.РЭНЧИН  
П.ОЧИРБАТ  
ЖАМАРСАНАА  
Ч.ДАШНЯМ**

## УНШИГЧДЫН АНХААРАЛД

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны нэгдүгээр сарын 28-ны өдрийн 4 дүгээрт нийтлэгдсэн “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн 5.1.5-д “оршуулгын зардлын 75 хувийг нийгмийн даатгалын сангаас” гэснийг “түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувийг тэнцэх хэмжээний тусламж” гэж, мөн хуулийн 7.1-ийн “5.1.6-д” гэснийг “5.1.5-д” гэж тус тус залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтэс

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265658  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2.5

